

С.Бүрэн: Сан дундраад 20 мянгатын дэвсгэрт хэвлүүлээ

Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газрын Мөнгөн тэмдэгтийн хэлтсийн эдийн засагч С.Бүрэнцогттой ярилцлаа.

А : 20 мянгатын дэвсгэртийг ямар шалтгааны улмаас шинээр хэлбэлүүлэв?

Х : Монголбанкинд Монголын улсын мөнгөн дэвсгэртийн нөөцийн сан гэж байдаг. Энэ санд төгрөгийн дэвсгэрт болгоны тогтсон хэмжээний нөөц байх ёстой. Энэ сангаас төгрөгийг шинэчилдэг юм. Сан дундраад ирэхээр дахин дэвсгэрт хэвлүүлдэг. Анх 20 мянгатын дэвсгэртийг 2006 онд үйлдвэрлэсэн. Тэр цагаас хойш нөөцийг нь дахин сэргээгээгүй. Нөөц нь эрс багасан тул дахин шинээр хэвлүүлээ.

А : Хэдэн ширхэг 20 мянгатын дэвсгэрт хэвлүүлсэн бэ?

Тоо нь нууцын зэрэглэлтэй байдаг. Мөнгөн дэвсгэртийн санд 500-гаас дээш дэвсгэрт таван сая ширхэгээс доошгүй байх ёстой. Түүнчлэн 500-гаас доош дэвсгэрт нэг сая ширхэгээс доошгүй байх ёстой. Нөөцийн хамгийн бага хэмжээ гэсэн үг. Үүнээс доош орвол дахиж хэвлүүлэх шаардлага бий болдог.

А : Гүйлгээнд 20 мянгатын дэвсгэрт хангалттай байхад хэвлүүлээ гэсэн шүүмжлэл гарах боллоо. Энэ тал дээр юу хэлэх вэ?

Бэлэн мөнгө эдийн засагт тарчихсан байдаг. Өөр хэлбэл, банк, байгууллагууд, иргэдийн байна гэсэн үг. Энэ мөнгө тодорхой хугацааны дараа элэгдэнэ, урагдана. Жишээ нь, Цагаан сараар шинэ дэвсгэртийг их хэмжээгээр зах зээл рүү нийлүүлдэг. Энэ мэтээр сангийн мөнгө дундардаг юм. Тиймээс нөөцийг нь зохистой хэмжээнд хүргэж хэвлүүлэх шаардлагатай байдаг. Захирлын зөвлөл хэвлэх тоог шийдээд, захиалаад, жилийн дараа хэвлэлтээс гардаг юм. Зах зээлд 20 мянгатын дэвсгэрт хангалттай бий. Харин хуучирч муудахад нь солих дэвсгэртийг хэвлэж байна гэж ойлгох хэрэгтэй.

А : Бас Монголбанкны ерөнхийлөгчөөр ажилласан хүн гарын үсэгтэй мөнгөн тэмдэгтээ хэвлүүлэхийг хүсдэг. Тиймээс Л.Пүрэвдорж ерөнхийлөгчийг гарын үсэгтэй мөнгөн дэвсгэртээ хэвлүүлэх зорилгоо биелүүлж байна гэх мэдээлэл ч цацагдсан?

Тийм зүйл огт байхгүй. Төв банк зах зээлийг бэлэн мөнгөний хомсдолд оруулахгүйн тулд мөнгөн дэвсгэртийг санг байнга дүүргэж байх үүрэгтэй. Түүнээс биш хэн нэг хувь хүний оролцоо давамгайлдаггүй юм. Яг ямар мөнгөн дэвсгэртийг хэдийн хэмжээгээр хэвлэх вэ гэдгээ захирлын зөвлөлд оруулдаг. Захирлын зөвлөл 11 гишүүнтэй. Тэд цугларч байж шийдвэр гаргадаг. Хэн нэг нь ашиг хийх гээд хэвлүүлдэггүй юм. Манай өмнөх тэргүүн дэд ерөнхийлөгчийг мөнгө

хэвлүүлж ашиг унагадаг. Хэвлүүлэх компаниа өөрөө олдог гэж бичиж байсан. Тийм утгагүй юм байхгүй.

А : Шинэ 20 мянгатын дэвсгэрт хэзээ гүйлгээнд гарах вэ?

Ирэх 7-8 дугаар сард гарна гэж тооцож байгаа. Мөнгө хэвлэлтээс ирээд сангийнхаа зузаатгалыг хийсэн.

А: Өнгө нь өөрчлөгдөх үү?

Өнгө хэвээрээ.

А: 20 мянгатын дэвсгэртийг дуурайлгаж хийсэн хэрэг гарах болсон. Нууцлал нэмсэн гэл үү?

Шинээр хоёр нууцлал нэмсэн. Мөнгөн тэмдэгтийн нууцлалыг аливаа технологийн дэвшилээс түрүүлж байх ёстой. Нэмж тунгалаг цонх хийсэн. Мөн ард нь солонгорч харагдах мөнгөлөг ялтас нэмсэн.